

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СНАГ-2024/21/НА-СТА-ТӨА

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он	Санхүү нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер Э.Энхбаатар Утас: 280512 Цахим хаяг: Enkhbaatare@audit.gov.mn Аудитор П.Ариунзаяа Утас: Цахим хаяг Ariunzayap@audit.gov.mn Цэгцтөв богд аудит ХХК-ийн захирал Н.Цэрэнханд Утас: 99901517 Цахим хаяг: tsegtstuvbogd@gmail.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1 Хөдөө аж ахуйн бирж ХХК , түүний үйл ажиллагаа	10
3.2 Компанийн гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	11
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	12
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал.....	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.5.1 Завсрын аудитын талаар	15
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	16
5.1 Албан шаардлага	16
5.2 Зөвлөмж.....	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХААХҮЯ	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Х.ОТГОНБАЯР
ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.17 № 07/1050
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд тогтоосон цалин дээр нь хуралдаанд оролцсон цагийн 23.6 сая төгрөгийн нэмэгдэл хөлс олгосон, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамыг Дархан-Уул аймагт нүүлгэн шилжүүлсэнтэй холбогдуулан орон сууц худалдан авах урьдчилгаа 30 хувийн төлбөрт нийт 3,126.4 сая төгрөгийг хуримтлагдсан ашгийг хорогдуулан зардал гаргасан зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 12, 21 дүгээр зүйл, Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5.1, ТБОНӨХБАҮХАТХ-ийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.7.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6 заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон тэмдэглэсэн хэсэг

Засгийн газрын 2024 оны 32 дугаар хуралдааны тэмдэглэлд "Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон түүний харьяа байгууллагуудыг Дархан-Уул аймагт нүүлгэн шилжүүлэх" гэж даалгасны дагуу тус биржийг нүүлгэн шилжүүлэх зардал, ажилтан албан хаагчдын орон сууцны урьдчилгаа болон бусад зардалд зарцуулсан 1,466.8 сая төгрөгөөр өмнөх үеийн хуримтлагдсан ашгийг бууруулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайланд онд хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн экспортын системийн динамик загварчлал боловсруулах, Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалтыг оновчтой хэлбэрээр зохион байгуулах, биржээр арилжаанд оруулах, экспортод гаргах, ноос ноолуурын салбарын өнөөгийн борлуулалт, гадаад дотоод зах зээлийн судалгаа, экспортын нөхцөл байдлыг судлах, түүхий эд бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгох, улаанбуудайн зах зээлийн судалгаа, түүхий эд бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгох зөвлөх үйлчилгээ, ноос ноолуурын салбарын үйлдвэрлэлийн өнөөгийн нөхцөл байдал, урамшууллын тогтолцоог судлах зөвлөх үйлчилгээ зэрэг судалгааны ажилд зарцуулсан нийт 482.6 сая төгрөгийн зардлын үр дүнг тооцох шаардлагатай байна.

Бусад асуудлын хэсэг

Хөдөө аж ахуйн бирж ХХК нь 2024 онд 187 удаагийн арилжаа зохион байгуулж, нийт 1,029.5 тэрбум төгрөгийн арилжаа хийсэн. Үүнд 5,863 тонн ямааны ноолуур, 3,365 тонн ямааны завод ноос, 6,340.0 тонн хонины ноос, 1,021 тонн тэмээний ноос, 4,422 тонн тосны ургамал /рапс/, зэрэг бараа, түүхий эдийг арилжсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	4,460,352,687.07	424,767,663.75
1.1.2	Дансны авлага	2,090,811,939.31	2,173,640,529.40
1.1.4	Бусад авлага	17,472,315.50	17,040,317.00
1.1.6	Бараа материал	11,905,674.36	42,821,272.10
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	37,164,156.00	
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	6,617,706,772.24	2,658,269,782.25
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,814,874,318.00	1,917,022,400.74
1.2.2	Биет бус хөрөнгө	1,450,665,127.86	1,243,816,385.01
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,265,539,445.86	3,160,838,785.75
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	9,883,246,218.10	5,819,108,568.00
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.1	Өр төлбөр	-	-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.1	Дансны өглөг	16,805,177.54	117,434,000.00
2.1.1.3	Татварын өр	553,055,141.09	290,029,137.00
2.1.1.12	Бусад богино хугацаат өр төлбөр	900,000.00	900,000.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	570,760,318.63	408,363,137.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	570,760,318.63	408,363,137.00
2.3	Эздийн өмч	-	-
2.3.1	Өмч: -төрийн	1,021,700,000.00	1,021,700,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	3,486,680.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	10,000.00	10,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	8,290,775,899.47	4,385,548,751.00
2.3.11	Эздийн өмчийн дүн	9,312,485,899.47	5,410,745,431.00
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	9,883,246,218.10	5,819,108,568.00

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	5,604,367,138.10	6,444,612,707.44
3	Нийт ашиг (алдагдал)	5,604,367,138.10	6,444,612,707.44
5	Хүүний орлого	31,010,130.62	149,509,539.41
8	Бусад орлого	2,500,622,382.00	-
9	Борлуулалт маркетингийн зардал	299,545,000.00	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	3,903,462,334.33	5,528,649,241.29
12	Бусад зардал	125,735,599.94	136,966,298.25
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	3,807,256,716.45	928,506,707.31
19	Орлогын татварын зардал	380,961,411.52	93,126,455.78
20	Татварын дараах ашиг (алдагдал)	3,426,295,304.93	835,380,251.53
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	3,426,295,304.93	835,380,251.53
24	Орлогын нийт дүн	3,426,295,304.93	835,380,251.53

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,021,700,000.00	-	10,000.00	5,458,489,437.01	6,480,199,437.01
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	86,112,442.47	86,112,442.47
Залруулсан үлдэгдэл	1,021,700,000.00	-	10,000.00	5,372,376,994.54	6,394,086,994.54
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	3,426,295,304.93	3,426,295,304.93
Зарласан ногдол ашиг	-	-	-	507,896,400.00	507,896,400.00
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,021,700,000.00	-	10,000.00	8,290,775,899.47	9,312,485,899.47
Залруулсан үлдэгдэл	1,021,700,000.00	-	10,000.00	8,290,775,899.47	9,312,485,899.47
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	835,380,251.53	835,380,251.53
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	(4,740,607,400.00)	(4,740,607,400.00)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	3,486,680.00	-	-	3,486,680.00
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,021,700,000.00	3,486,680.00	10,000.00	4,385,548,751.00	5,410,745,431.00

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	379,928,908,522.50	208,797,721,175.22
	Бусад мөнгөн орлого	379,928,908,522.50	208,797,721,175.22
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	381,166,343,209.45	218,855,174,464.55
	Ажиллагчдад төлсөн	1,075,596,937.21	1,415,871,789.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	358,448,067.08	434,367,659.37
	Бараа материал худалдан авахад төлсөн	14,721,724.52	22,619,577.00
	Ашиглалтын зардалд төлсөн	35,328,705.99	71,702,850.27
	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,350,000.00	2,250,000.00
	Татварын байгууллагад төлсөн	134,364,353.06	153,611,349.92
	Бусад мөнгөн зарлага	379,546,533,421.59	216,754,751,238.99
1.3	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	(1,237,434,686.95)	(10,057,453,289.33)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	31,010,130.62	149,509,539.41
	Хүлээн авсан хүүний орлого	31,010,130.62	149,509,539.41
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	193,837,097.10	356,979,670.00

	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	38,837,097.10	337,479,670.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	155,000,000.00	19,500,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	(162,826,966.48)	(207,470,130.59)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	507,896,400.00	-
	Төлсөн ногдол ашиг	507,896,400.00	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(507,896,400.00)	-
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(1,908,158,053.43)	(10,264,923,419.92)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	949,553,929.32	4,460,352,687.07
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,460,352,687.07	424,767,663.75

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Хэмжих нэгж	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
а) Арилжааны хэмжээ	тонн	27,129.0	47,233.9	20,104.9	174.1
Ноолуур	тонн	6,000.0	5,863.0	(137.0)	97.7
Хонины ноос	тонн	8,700.0	6,340.0	(2,360.0)	72.9
Тэмээний ноос	тонн	1,020.8	1,021.0	0.2	100.0
Ямааны завод ноос	тонн	3,159.0	3,365.0	206.0	106.5
Хонины завод ноос	тонн	108.5	27.0	(81.5)	24.9
Тосны ургамал	тонн	8,140.7	4,422.0	(3,718.7)	54.3
Мал бэлтгэл /хонин толгой/	амьд мал	6,000.0	7,942.0	1,942.0	132.4
Мах бэлтгэл /гулууз/	тонн	-	1,504.9	1,504.9	
Үрийн буудай	тонн	-	1,798.0	1,798.0	
Хүнсний буудай	тонн	-	14,951.0	14,951.0	
б) Арилжааны дүн	тэрбум.төг	997.7	1,029.5	31.8	103.2
Ноолуур	тэрбум.төг	891.6	889.7	(1.9)	99.8
Хонины ноос	тэрбум.төг	15.3	13.7	(1.6)	89.8
Ямааны завод ноос	тэрбум.төг	66.7	71.3	4.6	106.8
Тэмээний ноос	тэрбум.төг	12.6	12.6	-	100.0
Хонины завод ноос	тэрбум.төг	0.1	0.0	(0.1)	26.9
Тосны ургамал	тэрбум.төг	11.0	7.6	(3.4)	69.0
Мал бэлтгэл /хонин толгой/	тэрбум.төг	0.4	0.6	0.2	135.4
Мах бэлтгэл /гулууз/	тэрбум.төг	-	15.7	15.7	
Үрийн буудай	тэрбум.төг	-	2.8	2.8	
Хүнсний буудай	тэрбум.төг	-	15.4	15.4	
Нийт орлого	мян.төг	6,244,286.4	6,594,122.2	349,835.8	105.6
Нийт зардал	мян.төг	6,126,798.7	5,665,615.5	(461,183.2)	92.5
Татварын өмнөх ашиг	мян.төг	117,487.7	928,506.7	811,019.0	790.3
Цэвэр ашиг (алдагдал)	мян.төг	105,739.0	835,380.2	729,641.2	790.0
Нийт төсөвт төлөх татвар:	мян.төг	665,811.3	691,816.2	26,004.9	103.9
а) Орлогын татвар	мян.төг	11,748.8	93,126.5	81,377.7	792.6
б) ХХОАТ	мян.төг	174,525.4	164,322.1	(10,203.3)	94.2
в) ЭМНДШ	мян.төг	479,537.1	434,367.7	(45,169.4)	90.6
Нийт ажиллагсдын тоо	тоо	42	20	(22)	47.6
Нийт цалингийн сан	мян.төг	1,998,071.2	1,692,488.5	(305,582.7)	84.7
Ногдол ашиг	мян.төг	52,869.5	417,690.1	364,820.6	790.0
Авлага	мян.төг	-	2,173,640.5	2,173,640.5	
Өглөг	мян.төг	-	408,363.1	408,363.1	
Хөрөнгө оруулалт	мян.төг	470,625.0	360,466.3	(110,158.7)	76.6
Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төг	1.0	0.9	(0.1)	87.6

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Хөдөө аж ахуйн бирж ХХК , түүний үйл ажиллагаа

Хөдөө аж ахуйн бирж ХХК нь дүрэмдээ эрхэм зорилгоо “Монгол Улсад олон улсын стандартад нийцсэн хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн нэгдсэн тогтолцоог бий болгох, бараа түүхий эдийн арилжааг тогтсон журмын дагуу зориулалтын байранд /танхимын болон цахим сүлжээгээр/ зохион байгуулах, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлэх” гэж тодорхойлон үйл ажиллагаа явуулж байна.

Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн нэгдсэн тогтолцоо бий болгох, бараа, түүхий эдийн спот болон үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжааг эрхлэх, арилжааг тогтсон журмын дагуу зориулалтын байранд танхимын болон цахим сүлжээгээр зохион байгуулах” гэж тодорхойлжээ.

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Хөдөө аж ахуйн бирж ХХК нь Компанийн тухай хууль, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль зэрэг хууль эрх зүйн баримт бичгийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Хөдөө Аж Ахуйн Бирж ХХК-ийн гүйцэтгэх захирлаар 2024 оны 01 дүгээр сарын 15-нд 2024 онд хийж гүйцэтгэх дотоод хяналт, шалгалт хийх төлөвлөгөөг батлуулж, хяналтын журмыг үндэслэн 3 удаагийн шалгалт хийсэн, хяналтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг хэлтэс тус бүрээр дүгнэж 14 зөвлөмж хүргүүлж ажилласан байна. Зөвлөмжийн биелэлт 92.0 хувийн хэрэгжилттэй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2019 онд боловсруулсан бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,064.1 сая төгрөгөөр буюу 41.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4,460,352.7	424,767.7	(4,035,585.00)
Авлага	2,108,284.3	2,190,680.8	82,396.5
Бараа материал	11,905.7	42,821.3	30,915.6
Урьдчилж төлсөн зардал/ тооцоо	37,164.1	-	(37,164.1)
Үндсэн хөрөнгө	3,265,539.4	3,160,838.8	(104,700.6)
Нийт хөрөнгө	9,883,246.2	5,819,108.6	(4,064,137.6)
Өр төлбөр	570,760.3	408,363.2	(162,397.1)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	9,312,485.9	5,410,745.4	(3,901,740.5)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	9,883,246.2	5,819,108.6	(4,064,137.6)

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, богино хугацаат өр төлбөр, эздийн өмч данснууд байна.

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл нь 424.8 сая төгрөг болж 4,035.6 сая төгрөгөөр буурсан нь Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 02 дугаар тогтоол, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 25 дугаар тогтоолоор ХХААХҮЯ, түүний эрхлэх хүрээний агентлаг, төсөвт байгууллага, төрийн өмчит газруудыг Дархан-Уул аймаг руу нүүлгэн шилжүүлэхтэй холбогдуулан албан хаагчдын орон сууцны урьдчилгаа 30 хүртэл хувийг төлөх болон бусад зардалд зарцуулсан;

Авлага дансны үлдэгдэл 2,190.7 сая төгрөг болж өмнөх оноос 82.4 сая төгрөгөөр өссөн нь арилжааны шимтгэлийн орлогын авлага нэмэгдсэн;

Урьдчилж төлсөн зардал данс 37.2 сая төгрөгөөр буурсан нь 2023 онд үүссэн зардлыг тайлант оны зардалд хуваарилсан;

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл нь 3,160.8 сая төгрөг болж 104.7 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд шинээр 360.5 сая төгрөгийн биет болон биет бус хөрөнгө худалдаж авч, 465.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдэл байгуулсан;

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 408.4 сая төгрөг болж 162.4 сая төгрөгөөр буурсан нь дансны өр төлбөр 100.6 сая төгрөгөөр нэмэгдэж, татварын өр төлбөр 263.0 сая төгрөгөөр буурсан;

Эздийн өмч дансны үлдэгдэл 5,410.7 сая төгрөг болж 3,901.7 сая төгрөгөөр буурсан нь Хувьцаа эзэмшигчдийн болон Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор хуримтлагдсан ашгаас 4,740.6 сая төгрөг зарцуулснаар хасагдаж, дахин үнэлгээний хэрэгжсэн нэмэгдэл

3.5 сая төгрөг, тайлант үеийн үр дүн 835.4 сая төгрөгөөр нэмэгдсэн зэргээс тус тус шалтгаалсан байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Хөдөө аж ахуйн бирж ХХК нь техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн 2024 оны “Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө”-г баталсан, 2024 оны 09 дүгээр сарын 30-ны 19 дүгээр тогтоолоор тодотгон баталсан байна. Тодотголоор орлогыг 1,022.9 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталж тайлант оны нийт орлогыг 6,244.3 сая төгрөгөөр, нийт зардлыг 6,126.8 сая төгрөгөөр, 105.7 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 470.6 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 6,594.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 5,665.6 сая төгрөгийн зардал гарган, 835.4 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 6,594.1 сая төгрөг болж төлөвлөснөөс 349.8 сая төгрөг буюу 5.6 хувиар давсан нь харилцах дансны хүүгийн орлого 149.5 сая төгрөгөөр нэмэгдэж, ноолуурын зах зээлийн үнийн өсөлтөөс арилжааны шимтгэлийн орлого 3 хувиар өссөн зэргээс шалтгаалжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 5,665.6 сая төгрөг болж, төлөвлөснөөс 595.4 сая төгрөг дутуу зардал гаргасан байна. Энэ нь компани Дархан-Уул аймагт шилжин суурьшсантай холбогдуулан орон тоо цөөрсөн, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал, нийгмийн хамгаалал хүний нөөцийн үйл ажиллагааны зардлуудыг нөлөөлжээ.

Хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээнд 23 ажил төлөвлөснөөс 18 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 360.5 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 835.4 сая төгрөг болж, төлөвлөснөөс 729.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь борлуулалтын орлогыг 349.8 сая төгрөгөөр давуулан биелүүлж, нийт зардлыг 461.2 сая төгрөгөөр хэмнэж ажилласан нь нөлөөлжээ.

Тайлант онд Сангийн яамны Төрийн сангийн улсын төсвийн орлогын дансанд өмнөх оны ногдол ашиг төвлөрүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн компани түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн үйл ажиллагааг сайжруулах, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, төсвийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөж зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Цэгцтөв богд аудит ХХК-ийн ахлах аудитор Д.Өлзий-Орших, туслах аудитор П.Пунцаг нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг аудитын менежер Т.Энхцэцэг, захирал Н.Цэрэнханд нар, Санхүү, нийцлийн аудитын газрын аудитор П.Ариунзаяа, аудитын менежер Э.Энхбаатар, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц. Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг хэрэгжүүлсэн.

Хөдөө аж ахуйн бирж ХХК нь 2024 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 32 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 4,328.7 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 43.3 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу Компани 2024 онд хэмнэлтийн горимыг хэрэгжүүлж, бараа материал, хангамжийн зүйлс, шатахууны зардлыг 26.4 сая төгрөг, нийгмийн хамгаалал хүний нөөцийн үйл ажиллагааны зардлыг 13.7 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 100.3 сая төгрөгөөр тус тус хэмнэж нийт 140.4 сая төгрөгийн хэмнэлтийг гарган ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн 36.1 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 1 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод мэдээлсэн эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд нийт 668 ширхэг 31,913.6 сая төгрөгийн мэдээлэл байршуулахаас дараа жилийн зорилтот түвшний төслийн мэдээллээс бусдыг бүрэн хугацаанд нь байршуулсан байна

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон тендер шалгаруулалтын журмын дагуу төлөвлөөгүй байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 "Засгийн газар нь барааны ажлын үйлчилгээний гэсэн ангилал тус бүрээр дараахь босго үнийг тогтооно" 8.7.1 тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо бүх багцын нийлбэр өртгийг үндэслэл болгох, "Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалын 2 дугаар зүйлийн 2.9 "захиалагч өөрийн байгууллагын төсвийн хүрээнд хэрэгжүүлэх төлөвлөгөө хууль тогтоомжид нийцэж буй эсэхийг хянан цахим системээр батална" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль, тогтоомжийн дагуу худалдан авах ажиллагааг төлөвлөж, тайлагнаж байх зөвлөмж өгөв.

2. “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөл нь 2024 оны 12 дугаар тогтоолоор төлөөлөн удирдах зөвлөлийн 3 гишүүнд цалин хөлснөөс гадна гадаад томилолтын зардалд 36,109,526.00(гучин зургаан сая нэг зуун есөн мянга таван зуун хорин зургаан) төгрөгийн зардал гаргасан байна.

Энэ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 12-т "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсон төрийн албан хаагч эрх бүхий байгууллагаас тогтоосон цалин хөлснөөс бусад төрлийн шан харамж, урамшуулал авахыг хориглоно", Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”-ын 7.7 “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн энэ журамд заасан цалин хөлснөөс бусад баталгаа, хангамж эдлэхийг хориглоно”, Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-д "Компанийн дүрэмд дараах зүйлийг заавал тусгана", 16.2.5-д "хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөлийн энэ хуулиар тодорхойлсноос бусад бүрэн эрх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг гадаадад томилолтоор ажиллуулсан зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2024 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулан 433.2 сая төгрөгийн зөрчил илрүүлснийг шалгагдагч байгууллагад танилцуулан баталгаажуулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3,152.5 сая төгрөгийн 3 албан шаардлага, 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	3	3,152,485.0	3	3,152,485.0	100.0
Зөвлөмж	2	-	2	-	100.0
Нийт дүн	5	3,152,485.0	5	3,152,485.0	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 351 дүгээр тогтоолын хавсралтын 26-д “...Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийн цэвэр ашгийн дүнгээс Улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн хэмжээ 1,713,147.65 мянган төгрөг...” гэснийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 09 дугаар сарын 26-ны өдрийн 432 дугаар тогтоолоор хүчингүй болгосон тул тайлант онд Улсын төсвийн орлогын дансанд өмнөх оны ногдол ашиг төвлөрүүлээгүйг дараагийн аудитад анхаарах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,616.7 сая төгрөгийн зөрчил¹ илэрсэнд 2 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 3,616.7 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 3,573.4 сая төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны А/52 дугаар тушаалаар Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин хөлсний хэмжээг шинэчлэн тогтоож Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад үндсэн цалин дээр 10 хувийн нэмэгдэл хөлс 1.2 сая төгрөг, гишүүдэд хуралдаанд оролцсон цагийн нэмэгдэл хөлс 22.4 сая төгрөг нийт 23.6 сая төгрөг олгосон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 12 "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсон төрийн албан хаагч эрх бүхий байгууллагаас тогтоосон цалин хөлснөөс бусад төрлийн шан харамж, урамшуулал авахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдэд нэмэгдэл хөлс олгосон зөрчлийг таслан зогсоох.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамыг Дархан-Уул аймагт нүүлгэн шилжүүлсэнтэй холбогдуулан орон сууц худалдан авах урьдчилгаа 30 хувийн төлбөрт яамны 45 ажилтанд 2,808.4 сая төгрөг, Жижиг дунд үйлдвэрийн газрын 7 ажилтанд 318.0 сая төгрөг нийт 3,126.4 сая төгрөгийг Хувьцаа Эзэмшигчдийн Хурлын 2024 оны 02 дугаар тогтоолын дагуу "Хөдөө аж ахуйн бирж" ХХК-ийн хуримтлагдсан ашгийг хорогдуулан зардал гаргасан байна

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21-д "Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хөрөнгөөр хандив тусламж, түүнтэй адилтгах аливаа хөтөлбөр, арга хэмжээ, нийгмийн шинжтэй үйл ажиллагаа, төсвийн алдагдлыг санхүүжүүлэхийг хориглоно", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6."үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хуримтлагдсан ашгийг хорогдуулан нийгмийн шинжтэй үйл ажиллагаа санхүүжүүлсэн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Ажил гүйлгээтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаанд хамааралгүй арга хэмжээнд 230.0 сая төгрөг, Дархан-Уул аймагт зохиогдсон ургацын баярын арга хэмжээнд "Хүнсний хангамж-аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөн буюу "Хүнсний хувьсгал"-ын хүрээнд ТУЗ-ийн 2024 оны 20 дугаар тогтоолын дагуу 236.7 сая төгрөг, нийт 466.7 сая төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21-д "Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хөрөнгөөр хандив тусламж, түүнтэй

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

адилтгах аливаа хөтөлбөр, арга хэмжээ, нийгмийн шинжтэй үйл ажиллагаа, төсвийн алдагдлыг санхүүжүүлэхийг хориглоно”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6 "үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх", Засгийн газрын 2024 оны 166 дугаар тогтоолын хавсралт "шинэ хоршоо-чинээлэг малчин" арга хэмжээний төлөвлөгөөний 2 дахь хэсгийн 2.5 дахь заалт "Мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хоршоодыг чадавхжуулах, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, энэ хүрээнд мэдээллийн нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Компанийн үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаанд хамааралгүй аливаа хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх .

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 9 дүгээр сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл /мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн А/52 дугаар тушаалаар Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин хөлсний хэмжээг шинэчлэн тогтоож Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад үндсэн цалин дээр 10 хувийн нэмэгдэл хөлс 1.2 сая төгрөг, гишүүдэд хуралдаанд оролцсон цагийн нэмэгдэл хөлс 22.4 сая төгрөг нийт 23.6 сая төгрөг олгосон байна	1	23,628.0	-	-	1	23,628.0	-	-	-	-	-	-
Үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй "Шинэ хоршоо-чинээлэг малчин" арга хэмжээнд 230.0 сая төгрөг, Дархан уул аймагт зохиогдсон "Алтан намар" ургацын баярын арга хэмжээнд "Хүнсний хангамж-аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөн буюу "Хүнсний хувьсгал"-ын хүрээнд ТУЗ-ын 20 дугаар тогтоолын дагуу 236.7 сая төгрөг, нийт 466.7 сая төгрөг зарцуулсан байна.	1	466,698.6	-	-	-	-	1	466,698.6	-	-	-	-
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамыг Дархан уул аймагт нүүлгэн шилжүүлсэнтэй холбогдуулан Дархан уул аймагт орон сууц худалдан авах урьдчилгаа 30 хувийн төлбөрт ХХААХҮЯ-ны 45 ажилтанд 2,808.4 сая төгрөг, ЖДҮХГ-ын 7 ажилтанд 318.0 сая төгрөг нийт 3,126.4 сая төгрөгийг "Хөдөө аж ахуйн бирж" ХХК-ны хувьцаа эзэмшигчдийн хурлын 2024 оны 02 дугаар тогтоолын дагуу тус	1	3,126,400.0	-	-	1	3,126,400.0	-	-	-	-	-	-

Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

байгууллагын хуримтлагдсан ашгийг хорогдуулан зардал гаргасан байна												
Дүн	3	3,616,726.6	-	-	2	3,150,028.0	1	466,698.6	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон тендер шалгаруулалтын журмын дагуу төлөвлөөгүй байна.	1	-	-	-	1	-
"Компанийн дүрэм"-ийн 11 дүгээр зүйлийн 11.5-д "ТУЗ нь компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлд зааснаас бусад дараах бүрэн эрхтэй байна" гэж заасан бүрэн эрхэд төсөв хөрөнгө зарцуулахтай холбоотой эрх зүйн зохицуулалтгүй байхад ТУЗ-ийн 2024 оны 12 дугаар тогтоолоор тус биржийн төлөөлөн удирдах зөвлөлийн 3 гишүүнийг гадаадад томилолтоор ажиллуулсан байна.	1	36,109.5	1	36,109.5	-	-
Дүн	2	36,109.5	1	36,109.5	1	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 456/АДХ0069

Улаанбаатар хот

СНДГ-2023/24/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамыг Дархан-Уул аймагт нүүлгэн шилжүүлсэнтэй холбогдуулан орон сууц худалдан авах урьдчилгаа 30 хувийн төлбөрт яамны 45 ажилтанд 2,808,392,300.00 (хоёр тэр бум найман зуун найман сая гурван зуун ерөн хоёр мянга гурван зуун)төгрөг, Жижиг дунд үйлдвэрийн газрын 7 ажилтанд 318,008,100.00(гурван зуун арван найман сая найман мянга нэг зуун) төгрөг нийт 3,126,400,400.00 (гурван тэр бум нэг зуун хорин зургаан сая дөрвөн зуун мянга дөрвөн зуун) төгрөгийг Хувьцаа Эзэмшигчдийн Хурлын 2024 оны 02 дугаар тогтоолын дагуу "Хөдөө аж ахуйн бирж" ХХК-ийн хуримтлагдсан ашгийг хорогдуулан зардал гаргасан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21-д "Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хөрөнгөөр хандив тусламж, түүнтэй адилтгах аливаа хөтөлбөр, арга хэмжээ, нийгмийн шинжтэй үйл ажиллагаа, төсвийн алдагдлыг санхүүжүүлэхийг хориглоно", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6."үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх", 12 дугаар зүйлийн 12.1.Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно: 12.1.4.хуулиар зөвшөөрөөгүй бусад, 12.1 гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хуримтлагдсан ашгийг хорогдуулан нийгмийн шинжтэй үйл ажиллагаанд зарцуулсан зөрчлийг, таслан зогсоож давтан гаргахгүй байх биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн гүйцэтгэх захирал /Х.Отгонбаяр/, ерөнхий нягтлан бодогч /Б.Номин-Эрдэнэ/нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
Н.ЦЭРЭНХАНД



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 455/АД/50063

Улаанбаатар хот

Схем - 2025/24/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Хөдөө аж ахуйн бирж" ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөл нь 2024 оны 12 дугаар тогтоолоор төлөөлөн удирдах зөвлөлийн 3 гишүүнд цалин хөлснөөс гадна гадаад томилолтын зардалд 36,109,526.00(гучин зургаан сая нэг зуун есөн мянга таван зуун хорин зургаан) төгрөгийн зардал гаргасан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 12-т "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсон төрийн албан хаагч эрх бүхий байгууллагаас тогтоосон цалин хөлснөөс бусад төрлийн шан харамж, урамшуулал авахыг хориглоно", Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам"-ын 7.7 "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн энэ журамд заасан цалин хөлснөөс бусад баталгаа, хангамж эдлэхийг хориглоно", Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-д "Компанийн дүрэмд дараах зүйлийг заавал тусгана", 16.2.5-д "хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөлийн энэ хуулиар тодорхойлсноос бусад бүрэн эрх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг гадаадад томилолтоор ажиллуулсан зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн гүйцэтгэх захирал /Х.Отгонбаяр/, ерөнхий нягтлан бодогч /Б.Номин-Эрдэнэ/нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
Н.ЦЭРЭНХАНД

АТА9693 9006109
9023030583

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z: Alban Shoardlaga 2025 0314 SNAG-3.Docx



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 454/20150069

Улаанбаатар хот

СНМ-2025/04/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад үндсэн цалин дээр 10 хувийн нэмэгдэл хөлс 1,188,000.00 (нэг сая нэг зуун наян найман мянган) төгрөг, гишүүдэд хуралдаанд оролцсон цагийн нэмэгдэл хөлс 22,440,000.00(хорин хоёр сая дөрвөн зуун дөчин мянган) төгрөг нийт 23,628,000.00 (хорин гурван сая зургаан зуун хорин найман мянган) төгрөг олгосон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 12-т "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсон төрийн албан хаагч эрх бүхий байгууллагаас тогтоосон цалин хөлснөөс бусад төрлийн шан харамж, урамшуулал авахыг хориглоно" Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам"-ын 7.7 "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн энэ журамд заасан цалин хөлснөөс бусад баталгаа, хангамж эдлэхийг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдэд нэмэгдэл хөлс олгосон зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн гүйцэтгэх захирал /Х.Отгонбаяр/, ерөнхий нягтлан бодогч /Б.Номин-Эрдэнэ/нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Э.ЭНХБААТАР

Н.ЦЭРЭНХАНД

АГА9693 9006109
9023030583

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shuurdaga\2025\0314 SNAG-3 Docs